



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/36

Пионер толгой

Олон нийтэд сургалт зохион байгуулах,
сурталчилгаа мэдээлэл хүргэх ажилд
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 10/02 тоот тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2022-2023 оны гүйцэтгэл, үр дүнг тайлагнах, 2024 оны төлөвлөлтөд иргэдийн оролцоог хангах ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалт, сурталчилгаа, мэдээллийн ажлыг эрчимжүүлсүгэй.

2.Иргэд, олон нийтэд мэдээлэл хүргэх, сургалт сурталчилгаа зохион байгуулах, сумын Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааг сурталчилах, тайлагнах ажилд сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны төсөвт тусгагдсан 7,000,000 (Долоон сая) төгрөгийг зарцуулсугай.

3.Иргэд, олон нийтэд чиглэсэн сургалт мэдээллийн үйл ажиллагаанд шаардагдах 7,000,000 (Долоон сая) төгрөгийг холбогдох баримтыг үндэслэн тухай бүр санхүүжүүлэхийг Сан хариуцсан нягтлан бодогч (Б.Няммэший)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Сүглэгмаа) -д даалгасугай.

ДАРГА



Б.ГАНТУЛГА

642301255

2023/Засаг дарга/Захирамж2023